



МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН САЙДЫН
ТУШААЛ

2025 оны 08 сарын 29 өдөр

Дугаар А/692

Улаанбаатар хот

Цаг уур, орчны шинжилгээний газрын
үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын
бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, Монгол Улсын Их Хурлын “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” 2024 оны 13 дугаар тогтоол, Засгийн газрын 2025 оны 52 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Цаг уур, орчны шинжилгээний газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг 1 дүгээр, агентлагийн зохион байгуулалтын бүтцийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан дээрх хөтөлбөрт тусгагдсан стратегийн зорилт, үйл ажиллагааны чиглэл, зохион байгуулалтын бүтцийн хүрээнд агентлагийн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж, батлуулах болон харьяа байгууллагуудын стратеги, зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн баталж мөрдүүлэхийг Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга (Э.Баттулга)-д даалгасугай.

3.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан “Агентлагийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлах тухай” Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны А/458 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

Б.БАТБААТАР

1525002183

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
СТРАТЕГИ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН
ХӨТӨЛБӨР**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Оршил

Энэхүү баримт бичиг нь Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Цаг уур, орчны шинжилгээний газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн загварыг тодорхойлно. Цаг уур, орчны шинжилгээний газар нь Монгол Улсын хэмжээнд цаг уур, байгаль орчны хяналт шинжилгээ хийх, ус, цаг агаар, орчны төлөв байдал, чанарын талаарх мэдээллээр шуурхай үйлчлэх үйл ажиллагааг зохион байгуулж, байгаль, цаг агаарын болзошгүй эрсдэлээс эртнээс сэрэмжлүүлэх үүрэгтэй төрийн захиргааны байгууллага болно.

1.2. Үндэслэл

Хөтөлбөрийг Засгийн газрын тухай хууль, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль, Засгийн газрын агентлагийн талаар авах зарим арга хэмжээний тухай, Засгийн газрын 2025 оны 52 дугаар тогтоолын 1, 2 дугаар хавсралтаар баталсан Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлагийн жагсаалт, Засгийн газрын агентлагийн орон тооны хязгаарыг батлах тогтоолыг тус тус үндэслэн боловсруулав.

1.3. Хууль тогтоомжийн орчин

Хөтөлбөрийг дараах хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ:

Монгол Улсын Үндсэн хууль;
Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль;
Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль;
Төрийн албаны тухай хууль;
Төсвийн тухай хууль;
Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль;
Хууль тогтоомжийн тухай хууль;
Байгаль орчныг хамгаалах тухай хууль;
Агаарын тухай хууль;
Усны тухай хууль;
Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль;
“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого;
Шинэ сэргэлтийн бодлого;
Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал болон бусад холбогдох хууль тогтоомж.

1.4. Арга зүй

Хөтөлбөрийг боловсруулахад “Засгийн газрын агентлагийн талаар авах арга хэмжээний тухай” 2025 оны 52 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан

"Засгийн газрын агентлагийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн ерөнхий завар"-ыг удирдлага болгов.

1.5. Агентлагийн үүрэг, хариуцлага

Агентлаг нь Засгийн газар, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын өмнө ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээг байнгын тасралтгүй найдвартай ажиллуулж, ус, цаг агаар, уур амьсгал, байгаль орчны төлөв байдлын бодит болон урьдчилсан, урьдчилан сэргийлэх, тусгай хэрэгцээний мэдээ, мэдээллээр нийгмийн хэрэгцээг тасралтгүй хангах ажлыг зохион байгуулах, ус, цаг уур, орчны мэдээ, мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх, хэрэглэгчдэд үнэн зөв мэдээ, мэдээллийг шуурхай хүргэх замаар уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхыг бүрдүүлэх үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

1.6. Стратегийн удирдлага, зохицуулалтын үндсэн хэрэглэгч

Агентлагийн үйл ажиллагааны стратегийн удирдлага, зохицуулалтын үндсэн хэрэглэгч болон үйлчлүүлэгчийн бүлэг, тэдэнд үзүүлэх үйлчилгээг хэрэглэгчээр тодорхойлов.

Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагыг ус, цаг агаарын бодит, урьдчилсан болон урьдчилан сэргийлэх мэдээ, агаар, гадаргын, газрын доорх ус, хөрсний төлөв байдал, цацраг идэвхийн түвшний мэдээлэл, байгаль орчныг бохирдуулах эх үүсвэрээс ялгарах хаягдлын талаарх тоон үзүүлэлтүүд, холбогдох дүгнэлт, уур амьсгалын төлөв байдал, түүний өөрчлөлтийн ойрын, дунд хугацааны, хэтийн төлөвийн мэдээллээр үйлчлэх;

Улсын онцгой комисс, Онцгой байдлын ерөнхий газар, орон нутгийн онцгой байдлын албад ус, цаг агаарын гаралтай аюултай болон гамшигт үзэгдлийн мэдээ, мэдээллээр шуурхай үйлчлэх;

Иргэн, олон нийт, хэвлэл мэдээллийн байгууллагыг ус, цаг агаарын бодит болон урьдчилсан, урьдчилан сэргийлэх мэдээ, уур амьсгалын мэдээлэл, агаар, ус, хөрсний төлөв байдлын мэдээллээр үйлчлэх;

Нийгэм, эдийн засгийн салбарууд, аж ахуйн нэгж, байгууллагыг ус, цаг агаарын бодит, урьдчилсан болон урьдчилан сэргийлэх, тусгай хэрэгцээний мэдээ, агаар, гадаргын ус, хөрсний чанарын бодит мэдээ, уур амьсгалын горимын мэдээ, орчны бохирдлын эх үүсвэрээс ялгарч байгаа бохирдуулах бодисын тоон үзүүлэлтүүд, холбогдох мэргэжлийн дүгнэлт, уур амьсгалын төлөв байдал, түүний өөрчлөлтийн ойрын, дунд хугацааны болон хэтийн төлөвийн мэдээллээр үйлчилнэ.

Хоёр. Агентлагийн үйл ажиллагааны стратеги

2.1. Үйл ажиллагааны стратегийн мөн чанар

Монгол орны ус, цаг агаар, уур амьсгал, орчны нөөц, төлөв байдал, чанарт байнгын хяналт шинжилгээ хийж, уур амьсгал, усны нөөц, байгаль, цаг агаарын тааламжтай нөхцөлийг эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэхэд бүрэн дүүрэн ашиглах боломжоор хангах, байгаль, цаг агаарын болзошгүй аюул гамшиг, орчны ноцтой бохирдлоос урьдчилан сэргийлж, нийгэм, эдийн засагт болон иргэдэд учруулах хохирлыг багасгаж, улс орны урт хугацааны тогтвортой хөгжлийг хангахад оршино.

2.2. Тэргүүлэх чиглэл

Агентлаг нь дор дурдсан үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлтэй ажиллана:

2.2.1. Монгол Улсын хэмжээнд ус цаг уур, байгаль орчны төлөв байдал, чанарын хяналт шинжилгээг зохион байгуулж, хэрэглэгчийг мэдээллээр шуурхай хангах, ус, цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн улмаас үүсэж болзошгүй эрсдэлээс эртнээс сэрэмжлүүлэх;

2.2.2. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээг нэгдсэн удирдлага, нэгдмэл арга зүйгээр хангах, өргөжүүлэх, чадавхыг бэхжүүлэх;

2.2.3. Ус, цаг агаар, байгаль орчны төлөв байдлын бодит болон урьдчилсан, урьдчилан сэргийлэх, тусгай хэрэгцээний мэдээ, мэдээллээр нийгмийн хэрэгцээг тасралтгүй хангах, нийгмийн хэрэгцээнд тулгуурласан ус цаг уурын орчны мэдээ мэдээллээр мэргэжлийн түвшинд чанартай, шуурхай үйлчилгээ үзүүлэх;

2.2.4. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний үйл ажиллагааг тасралтгүй явуулж, мэдээлэл цуглуулах, техникийн найдвартай ажиллагааг хангах, техник технологийн байнгын шинэчлэл хийх, инноваци, ногоон технологи, шинжлэх ухааны судалгаа, ололт, сайн туршлагыг нэвтрүүлэх;

2.2.5. Хэмжлийн технологи олон улсын стандарт зааврыг мөрдүүлэх, салбарын хэмжээнд төсөв санхүү, хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд хяналт тавих, хяналт шалгалт хийх, зөвлөгөө, зөвлөмж өгөх, эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх;

2.2.6. Салбарын захиргааны нэгдсэн тогтолцоо, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, гадаад дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, мэргэжлийн хүний нөөцийг бүрдүүлж, чадавхжуулах;

2.2.7. Ус цаг уур, орчны мэдээллийн баримтын архив, тоон мэдээллийн нэгдсэн сан үүсгэх өргөжүүлэн хөгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, мэдээллийн сангийн өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэх, хэрэглэгчдэд мэдээллээр үйлчлэх;

2.2.8. Салбарын бодлого, стратеги төлөвлөгөө, харьяа байгууллага, нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх санхүү, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд хараат бус, бодитой дотоод аудит хийх, төрийн албан хаагчийн хууль бус үйлдэл, зөрчилтэй холбоотой иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирсэн албан бичиг, өргөдөл гомдлыг шийдвэрлэх.

2.3. Эрхэм зорилго

Ус, цаг агаар, байгаль орчны төлөв байдалд байнгын хяналт шинжилгээ, судалгаа хийж, бодит болон урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллээр нийгмийн хэрэгцээг шуурхай хангах, байгалийн болзошгүй гамшгийн эрсдэлээс сэрэмжлүүлэхэд оршино.

2.4. Үйл ажиллагааны стратегийн зорилт

Агентлаг нь эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтуудыг хэрэгжүүлнэ:

2.4.1. Богино болон дунд хугацааны цаг агаарын урьдчилсан мэдээ, цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн сэрэмжлүүлэх мэдээллийг салбарын хэмжээнд нэгэн утгатайгаар гаргах, аргазүйн удирдлагаар хангах, ус, цаг агаар, бодит болон урьдчилсан мэдээ, мэдээллийг хэрэглэгчдэд шуурхай хүргэх үйл ажиллагааг зохион байгуулж, болзошгүй байгаль, цаг агаарын гамшгийн эрсдэлээс сэрэмжлүүлэх;

2.4.2. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээг мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах, сүлжээний техник, технологийн шинэчлэл, төлөвлөн хэрэгжүүлэх, хэмжилзүй, хэмжлийн технологи, стандартын нэгдмэл байдлыг хангах, дотоодын болон олон улсын мэдээ солилцооны хэвийн ажиллагаа, аюулгүй байдлыг хангах;

2.4.3. Орчны бодит болон ирээдүйн төлөв байдал, өөрчлөлтийг үнэлэх, дүгнэлт гаргах, бохирдлын эх үүсвэрийн мэдээллийн санг бүрдүүлэх, мэдээ, мэдээллээр үйлчлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;

2.4.4. Салбарын мэдээлэл технологийн хэвийн ажиллагаа, цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, программ хангамж, хөгжүүлэлт, ашиглалт, мэдээллийн дотоод болон гадаад аюулгүй байдлыг хангах, иргэдэд үзүүлэх үйлчилгээг мэдээлэл технологийн шинэлэг шийдлээр түргэн шуурхай хялбараар хүргэх, үр дүнг тооцох;

2.4.5. Ус цаг уур, орчны мэдээллийн баримтын архивыг эрхлэх, уур амьсгал, ус, цаг уур, орчны мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, цахимжуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, мэдээний бүрэн бүтэн, нээлттэй байдал, хадгалалт хамгаалалтыг зохион байгуулах, хэрэглэгчдийг тоон мэдээ болон цаасан суурьтай мэдээллээр үйлчлэх;

2.4.6 Гадаад, дотоодын хамтын ажиллагаа, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, өргөжүүлэх;

2.4.7. Салбарын санхүү бүртгэл, төсвийн төлөвлөлт зарцуулалтад хяналт тавих, гэрээ, худалдан авалт, хангамж, өмчийн харилцааг зохицуулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, тайлагнах;

2.4.8. Цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах, үйл ажиллагааны менежментийг боловсронгуй болгох;

2.4.9. Цаг уур, орчны хяналт шинжилгээний салбар байгууллагын үйл ажиллагаанд хараат бус, бодитой хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит явуулах, дүгнэлт, зөвлөмж гаргах, хяналт шалгалт хийх.

2.5. Үйл ажиллагааны гол зорилт

Агентлагийн үйл ажиллагааны стратегийн зорилт тус бүрийн хүрээнд хууль, тогтоомж, тушаал, шийдвэрийг хэрэгжүүлэхээс гадна дор дурдсан үйл ажиллагааны гол зорилтыг хэрэгжүүлнэ.

2.5.1. Үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд:

2.5.1.1. Нийтийн хэрэгцээний цаг агаарын урьдчилсан мэдээг бүс нутаг, хот суурингаар гаргаж, түгээх үйл ажиллагааг зохион байгуулах;

2.5.1.2. Цаг агаарын аюултай үзэгдлээс сэрэмжлүүлэх, урьдчилан сэргийлэх, мэдээллийг урьдчилан мэдээлэх салбарын хэмжээнд нэгэн утгатайгаар гаргаж, түгээх үйл ажиллагааг зохион байгуулах;

2.5.1.3. Тусгай хэрэгцээний мэдээ буюу нийгэм эдийн засгийн бусад салбарууд, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад цаг агаарын урьдчилсан мэдээ, аюултай үзэгдлийн сэрэмжлүүлэх мэдээгээр үйлчлэх;

2.5.1.4. Орон нутгийн урьдчилан мэдээлэх хэсгүүдийг технологи, арга зүйн удирдлагаар хангах;

2.5.1.5. Урьдчилан мэдээлэх салбарын техник, технологийн шинэчлэлтийн санал боловсруулах, тасралтгүй сайжруулах, нэвтрүүлэх.

2.5.2. Үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд:

2.5.2.1. Улсын сүлжээний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, сүлжээний бүтэц, зохион байгуулалтыг төлөвлөх, өргөтгөх;

2.5.2.2. Улсын сүлжээний технологи, стандарт, арга зүйг Дэлхийн цаг уурын байгууллагын зөвлөмжид нийцүүлж боловсруулах, хяналт тавих;

2.5.2.3. Техник, технологийн шинэчлэлийг тасралтгүй хийж, хэмжих хэрэгсэл, хэмжлийн чанарт хяналт тавих, цахим технологи, автомат станц нэвтрүүлэх;

2.5.2.4. Хэмжлийн нэгдмэл байдлыг хангаж, олон улсын жишигт нийцүүлж удирдан зохион байгуулах;

2.5.2.5. Дотоодын болон олон улсын мэдээ солилцоо, мэдээллийн технологийн техник, тоног төхөөрөмжүүдийн хэвийн ажиллагаа, аюулгүй байдлыг хангах;

2.5.2.6. Хүрээлэн буй орчны чанарын хяналт шинжилгээ, байгаль орчны чиглэлийн лабораториудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

2.5.2.7. Агаар, ус хөрсний чанар, цацраг идэвхийн түвшний хяналт шинжилгээний үйл ажиллагаа, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах.

2.5.3. Үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд:

2.5.3.1. Орчны бохирдлын төлөв байдлыг үнэлэх, мэдээлэх, бохирдлын эх үүсвэр, ялгарлын тоо бүртгэлийн ажлыг зохион байгуулах, бохирдлын эх үүсвэрийн мэдээллийн санг бүрдүүлэх, иргэн аж ахуйн нэгж байгууллагад мэдээ, мэдээллээр үйлчлэх, дүгнэлт гаргах, зөвлөгөө өгөх, хянах;

2.5.3.2. Байгаль орчинд хаягдаж буй бохирдуулах бодисын бодит болон ирээдүйн өөрчлөлтөд үнэлэлт, дүгнэлт өгөх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;

2.5.3.3. Орчны бохирдол, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөхөд судалгаа, мэдээллийн дэмжлэг үзүүлэх.

2.5.4. Үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд:

2.5.4.1. Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, уг ажлыг нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангах, орчны бохирдлыг бууруулах технологийн шийдлүүд боловсруулах, цаг агаарт зориудаар нөлөөлөх хөтөлбөр, аргачлал боловсруулах, бусад байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа явуулах;

2.5.4.2. Эрт сэрэмжлүүлэх тогтолцоог бүрдүүлэх зорилгоор байгалийн гамшгийг урьдчилан мэдээлэх автомат системүүд хөгжүүлэх, хиймэл дагуул, дрон, юмсын интернэт (IoT) ашиглан цаг уурын хяналтын сүлжээ байгуулах;

2.5.4.3. Хиймэл оюун ухаан болон машин сургалтад суурилсан цаг агаарын таамаглалыг боловсронгуй болгох;

2.5.4.4. Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад уур амьсгалын өөрчлөлт, байгалийн гамшгийн эрсдэлийн удирдлагын чиглэлээр мэдээлэл түгээх, хамтран ажиллах, их дээд сургуулиуд, судалгааны байгууллагуудтай хамтарсан төсөл хэрэгжүүлэх;

2.5.4.5. Цаг уурын мэдээллийн технологийн шинэчлэлийг хийх хүрээнд цаг уурын өгөгдөл боловсруулах, загварчлах системүүдийг сайжруулах, өгөгдөл хадгалах, дамжуулах, анализ хийх дэвшилтэт программ хангамж нэвтрүүлэх, үүлэн технологи, их өгөгдөл ашиглан цаг уурын мэдээллийн хүртээмжийг сайжруулах, иргэдэд зориулсан интерактив платформ хөгжүүлэх;

2.5.4.6. Дэлхийн цаг уурын байгууллага (WMO), бүс нутгийн цаг уурын төвүүдтэй хамтран ажиллахын зэрэгцээ байгалийн гамшгаас хамгаалах олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх, гамшгийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн шилдэг туршлагыг нэвтрүүлэх;

2.5.4.7. Газар, сансрын мэдээг хам байдлаар ашиглан мониторинг хийх;

2.5.4.8. Нөлөөлөл, эрсдэлийн прогнозыг нийгэм, эдийн засгийн салбаруудаар гарган, бодлогын шийдэл болгон зөвлөн туслах.

2.5.5. Үйл ажиллагааны стратегийн 5 дугаар зорилтын хүрээнд:

2.5.5.1. Ус, цаг уур, орчны мэдээллийн төрийн төрөлжсөн архивыг эрхлэх, цахим архив бүрдүүлэх, цахимжуулах, мэдээ баримтын бүрэн бүтэн, нээлттэй байдал, хадгалалт, хамгаалалтыг удирдан зохион байгуулах;

2.5.5.2. Ус, цаг уур, орчны мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, баяжуулах, хиймэл оюун ухааны хэрэглээг нэвтрүүлэх, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, мэдээллийн үнэн зөв, аюулгүй байдлыг хангах, ашиглах үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

2.5.5.3. Ус, цаг уур-уур амьсгал, хөдөө аж ахуйн цаг уур, орчны чанарын горимын болон төрөлжсөн сангаас үнэн зөв, баталгаажсан мэдээгээр, төрөлжсөн

төрийн архиваас цахим болон цаасан суурьтай баримтаар батлагдсан үнэ тарифын дагуу чанарын өндөр түвшинд үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх.

2.5.6. Үйл ажиллагааны стратегийн 6 дугаар зорилтын хүрээнд:

2.5.6.1. Цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын олон улсын байгууллагууд (WMO, UNEP, UNFCCC, RIMES зэрэг)-тай хамтран ажиллах, олон улсын гэрээ, хэлэлцээр, санамж бичиг, хөтөлбөр, төслийг санаачлах, боловсруулах;

2.5.6.2. Хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийг эрх бүхий байгууллагаар батлуулах, гадаад хамтын ажиллагааны богино, дунд, урт хугацааны стратеги, төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтийг хангах;

2.5.6.3. Гадаад, дотоод хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжих төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагааг зохион байгуулан хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах.

2.5.7. Үйл ажиллагааны стратегийн 7 дугаар зорилтын хүрээнд:

2.5.7.1. Цаг уур, орчны шинжилгээний салбарын хэмжээний төлөвлөлт, хөрөнгө оруулалт, санхүү бүртгэлийн үйл ажиллагааг зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгөх, дүгнэлт гаргах;

2.5.7.2. Хяналт шинжилгээний улсын сүлжээний байнгын тасралтгүй, найдвартай ажиллагааг санхүүжилтээр хангах, өмч, хөрөнгийн хуваарилалт хийх, зохицуулалтыг тайлагнах, худалдан авалтын үйл ажиллагааг хариуцах;

2.5.7.3. Нягтлан бодох бүртгэл, аж ахуйн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж, төсвийн санхүүжилтийг үр ашигтай зарцуулах, тайлагнах;

2.5.7.4. Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах, хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалт, төсвийн орлого нэмэгдүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.

2.5.8. Үйл ажиллагааны стратегийн 8 дугаар зорилтын хүрээнд:

2.5.8.1. Цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын удирдлагын манлайллыг хангах;

2.5.8.2. Салбарын хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, чадавхыг бэхжүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

2.5.8.3. Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, стандартад нийцүүлэх, Газрын даргын шийдвэр, баримт бичгийн боловсруулалт, хэрэгжилтэд хяналт тавих.

2.5.9. Үйл ажиллагааны стратегийн 9 дүгээр зорилтын хүрээнд:

2.5.9.1. Салбарын бодлого төлөвлөлт, хууль тогтоомж, холбогдох хөтөлбөр, гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа төслийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг үнэлж, дүгнэлт, зөвлөмж гаргах, үнэлгээний талаарх мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг хангах;

2.5.9.2. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн дотоод аудитын чиг үүргийг

хэрэгжүүлэх;

2.5.9.3. Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт хийх, төрийн албан хаагчийн хууль бус үйлдэл, зөрчилтэй холбоотой өргөдөл гомдол шийдвэрлэх.

2.6. Үйл ажиллагааны зорилт

Агентлагийн үйл ажиллагааны гол зорилтууд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг болон албан хаагчдын ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтод тусган хэрэгжүүлнэ.

2.7. Үйл ажиллагааны стратегийн загвар

Агентлагийн үйл ажиллагааны стратегийг дараах загвараар тодорхойлж байна.

Ус цаг уур, орчны шинжилгээний үйл ажиллагааны стратегийн загвар:

Эрхэм зорилго	Үйл ажиллагааны стратегийн зорилт	Үйл ажиллагааны гол зорилт
Ус, цаг агаар, байгаль орчны төлөв байдалд байнгын хяналт шинжилгээ, судалгаа хийж, бодит болон урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллээр нийгмийн хэрэгцээг шуурхай хангах, байгалийн болзошгүй гамшгийн эрсдэлээс сэрэмжлүүлэхэд оршино.	Богино болон дунд хугацааны цаг агаарын урьдчилсан мэдээ, цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн сэрэмжлүүлэх мэдээллийг салбарын хэмжээнд нэгэн утгатайгаар гаргах, технологи, аргазүйн удирдлагаар хангах, ус, цаг агаар, бодит болон урьдчилсан мэдээ, мэдээллийг хэрэглэгчдэд шуурхай хүргэх үйл ажиллагааг зохион байгуулж, болзошгүй байгаль, цаг агаарын гамшгийн эрсдэлээс сэрэмжлүүлэх	Нийтийн хэрэгцээний цаг агаарын урьдчилсан мэдээг бүс нутаг, хот сууринаар гаргаж, түгээх үйл ажиллагааг зохион байгуулах
		Цаг агаарын аюултай үзэгдлээс сэрэмжлүүлэх, урьдчилан сэргийлэх, мэдээллийг салбарын хэмжээнд нэгэн утгатайгаар гаргаж, түгээх үйл ажиллагааг зохион байгуулах
		Тусгай хэрэгцээний мэдээ буюу нийгэм эдийн засгийн бусад салбарууд, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад цаг агаарын урьдчилсан мэдээ, аюултай үзэгдлийн сэрэмжлүүлэх мэдээгээр үйлчлэх
		Орон нутгийн урьдчилан мэдээлэх хэсгүүдийг технологи, арга зүйн удирдлагаар хангах
		Урьдчилан мэдээлэх салбарын техник, технологийн шинэчлэлтийн санал боловсруулах, тасралтгүй сайжруулах, нэвтрүүлэх
Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээг мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах, сүлжээний техник, технологийн шинэчлэл, төлөвлөн хэрэгжүүлэх, хэмжилзүй, хэмжлийн		Улсын сүлжээний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, сүлжээний бүтэц, зохион байгуулалтыг төлөвлөх, өргөтгөх
		Улсын сүлжээний технологи, стандарт, арга зүйг Дэлхийн Цаг Уурын Байгууллагын зөвлөмжид нийцүүлж боловсруулах, хяналт тавих

	технологи, стандартын нэгдмэл байдлыг хангах, дотоодын болон олон улсын мэдээ солилцооны хэвийн ажиллагаа, аюулгүй байдлыг хангах;	Техник, технологийн шинэчлэлийг тасралтгүй хийж, хэмжих хэрэгсэл, хэмжлийн чанарт хяналт тавих, цахим технологи, автомат станц нэвтрүүлэх
		Хэмжлийн нэгдмэл байдлыг хангаж, олон улсын жишигт нийцүүлж ажиллах
		Дотоодын болон олон улсын мэдээ солилцоо, мэдээллийн технологийн техник, тоног төхөөрөмжүүдийн хэвийн ажиллагаа, цахим сүлжээний аюулгүй байдлыг хангах
		Хүрээлэн буй орчны чанарын хяналт шинжилгээ, байгаль орчны чиглэлийн лабораториудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах
		Агаар, ус хөрсний чанар, цацраг идэвхийн түвшний хяналт шинжилгээний үйл ажиллагаа, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах.
	Орчны бодит болон ирээдүйн төлөв байдал, өөрчлөлтийг үнэлэх, дүгнэлт гаргах, бохирдлын эх үүсвэрийн мэдээллийн санг бүрдүүлэх, мэдээ, мэдээллээр үйлчлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх	Орчны бохирдлын төлөв байдлыг үнэлэх, мэдээлэх, бохирдлын эх үүсвэр, ялгарлын тоо бүртгэлийн ажлыг зохион байгуулах, бохирдлын эх үүсвэрийн мэдээллийн санг бүрдүүлэх, иргэн аж ахуйн нэгж байгууллагад мэдээ, мэдээллээр үйлчлэх, дүгнэлт гаргах, зөвлөгөө өгөх, хянах
		Байгаль орчинд хаягдаж буй бохирдуулах бодисын бодит болон ирээдүйн өөрчлөлтөд үнэлэлт, дүгнэлт өгөх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх
		Орчны бохирдол, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөхөд судалгаа, мэдээллийн дэмжлэг үзүүлэх
	Салбарын мэдээлэл технологийн хэвийн ажиллагаа, цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, програм хангамж, хөгжүүлэлт, ашиглалт, мэдээллийн дотоод болон гадаад аюулгүй байдлыг хангах, иргэдэд үзүүлэх үйлчилгээг мэдээлэл технологийн шинэлэг шийдлээр түргэн шуурхай хялбараар хүргэх. цаг агаарт зориудаар нөлөөлөх ажлыг удирдан зохион байгуулах, үр дүнг тооцох	Эрт сэрэмжлүүлэх тогтолцоог бүрдүүлэх зорилгоор байгалийн гамшгийг урьдчилан мэдээлэх автомат системүүд хөгжүүлэх, хиймэл дагуул, дрон, IoT (Интернетэд суурилсан төхөөрөмжүүд) ашиглан цаг уурын хяналтын сүлжээ байгуулах
		Эрт сэрэмжлүүлэх тогтолцоог бүрдүүлэх зорилгоор байгалийн гамшгийг урьдчилан мэдээлэх автомат системүүд хөгжүүлэх, хиймэл дагуул, дрон, юмсын интернэт ашиглан цаг уурын хяналтын сүлжээ байгуулах
		Хиймэл оюун ухаан болон машин сургалтад суурилсан цаг агаарын таамаглалыг боловсронгуй болгох
		Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад уур амьсгалын

		өөрчлөлт, байгалийн гамшгийн эрсдэлийн удирдлагын чиглэлээр мэдээлэл түгээх, хамтран ажиллах, их дээд сургуулиуд, судалгааны байгууллагуудтай хамтарсан төсөл хэрэгжүүлэх Цаг уурын мэдээллийн технологийн шинэчлэлийг хийх хүрээнд цаг уурын өгөгдөл боловсруулах, загварчлах системүүдийг сайжруулах, өгөгдөл хадгалах, дамжуулах, анализ хийх дэвшилтэт программ хангамж нэвтрүүлэх, үүлэн технологи, их өгөгдөл ашиглан цаг уурын мэдээллийн хүртээмжийг сайжруулах, иргэдэд зориулсан интерактив аппликейшн, платформ хөгжүүлэх Дэлхийн цаг уурын байгууллага (WMO), бүс нутгийн цаг уурын төвүүдтэй хамтран ажиллахын зэрэгцээ байгалийн гамшгаас хамгаалах олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх, гамшгийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн технологийн шилдэг туршлагыг нэвтрүүлэх Газар, сансрын мэдээг хам байдлаар ашиглан мониторинг хийх Нөлөөлөл, эрсдэлийн прогнозыг нийгэм, эдийн засгийн салбаруудаар гарган, бодлогын шийдэл болгон зөвлөн туслах
		Ус цаг уур, орчны мэдээллийн төрийн архивыг эрхлэх, уур амьсгал, ус, цаг уур, орчны мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, цахимжуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, мэдээний бүрэн бүтэн, нээлттэй байдал, хадгалалт хамгаалалтыг зохион байгуулах, хэрэглэгчдийг тоон мэдээ болон цаасан суурьтай мэдээллээр үйлчлэх
		Ус, цаг уур, орчны мэдээллийн төрийн төрөлжсөн архивыг эрхлэх, цахим архив бүрдүүлэх, цахимжуулах, мэдээ баримтын бүрэн бүтэн, нээлттэй байдал, хадгалалт, хамгаалалтыг удирдан зохион байгуулах Ус, цаг уур, орчны мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, баяжуулах, хиймэл оюун ухааны хэрэглээг нэвтрүүлэх, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, мэдээллийн үнэн зөв, аюулгүй байдлыг хангах, ашиглах үйл ажиллагааг удирдан зохион байгуулах Ус, цаг уур-уур амьсгал, хөдөө аж ахуйн цаг уур, орчны чанарын горимын болон төрөлжсөн сангаас үнэн зөв, баталгаажсан мэдээгээр, төрөлжсөн архиваас цахим болон цаасан суурьтай баримтаар батлагдсан үнэ тарифын дагуу чанарын өндөр түвшинд үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх
		Гадаад, дотоодын хамтын ажиллагаа, төсөл,
		Цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын олон улсын байгууллагууд

	хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, өргөжүүлэх	(WMO, UNEP, UNFCCC, RIMES зэрэг)-тай хамтран ажиллах, олон улсын гэрээ, хэлэлцээр, санамж бичиг, хөтөлбөр, төслийг санаачлах, боловсруулах Хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийг эрх бүхий байгууллагаар батлуулах, гадаад хамтын ажиллагааны богино, дунд, урт хугацааны стратеги, төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтийг хангах Гадаад, дотоод хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжих төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагааг зохион байгуулан хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах
	Салбарын санхүү, хөрөнгө оруулалт, төлөвлөлт, санхүү, бүртгэл төсвийн үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих, гэрээ, худалдан авалт, хангамж, өмчийн харилцааг зохицуулах, үр ашигтай зарцуулах, тайлагнах	Цаг уур, орчны шинжилгээний салбарын хэмжээний төлөвлөлт, хөрөнгө оруулалт, санхүү бүртгэлийн үйл ажиллагааг зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгөх, дүгнэлт гаргах Хяналт шинжилгээний улсын сүлжээний байнгын тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах, техник хангамж, худалдан авалтын үйл ажиллагааг хариуцан, хэрэгцээ өмч, хөрөнгийн зохицуулалт хийх, тайлагнах, хуваарилалт, хэрэгцээ шаардлагыг худалдан авалтын үйл ажиллагааг хариуцах Нягтлан бодох бүртгэл, аж ахуйн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж, төсвийн санхүүжилтийг үр ашигтай зарцуулах, тайлагнах Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах, хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалт, төсвийн орлого нэмэгдүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх
	Цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах, үйл ажиллагааны менежментийг боловсронгуй болгох	Цаг уур, орчны шинжилгээний салбарын удирдлагын манлайллыг хангах Салбарын хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, чадавхыг бэхжүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, стандартад нийцүүлэх, Газрын даргын шийдвэр, баримт бичгийн боловсруулалт, хэрэгжилтэд хяналт тавих
	Цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын байгууллагын үйл ажиллагаанд хараат бус, бодитой хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод	Салбарын бодлого төлөвлөлт, хууль тогтоомж, холбогдох хөтөлбөр, гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа төслийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг үнэлж,

	аудит явуулах, зөвлөмж гаргах, шалгалт хийх	дүгнэлт, хяналт	дүгнэлт, зөвлөмж гаргах, үнэлгээний талаарх мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг хангах
			Төсвийн төвлөрүүлэн захирагчийн дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлэх
			Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт хийх, төрийн албан хаагчийн хууль бус үйлдэл, зөрчилтэй холбоотой өргөдөл гомдол шийдвэрлэх

**Гурав. Агентлагийн бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын
бүтцийн нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг**

3.1. Бүтцийн ерөнхий тогтолцоо боловсруулахад баримталсан зарчим

Агентлагийн бүтцийн ерөнхий тогтолцоо боловсруулахад дараах зарчмыг баримталсан.

Агентлагийн үйл ажиллагааны стратегийн зорилтыг бүтцэд тусгах (тус агентлагийн үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц нь түүний үйл ажиллагааны стратегийн зорилттой уялдсан);

Эрх мэдлийн ялгаа зааг нь тодорхой, итгэл хүлээхүйц (бүтцийн нэгжүүд, тэдгээрийн удирдах албан тушаалын түвшин, тухайн нэгж ямар асуудал эрхэлдэг, тухайн албан тушаалтан ямар эрх мэдэлтэй болохыг тодорхой мэдэж болохуйц, тэдгээрийн ажлын уялдаа, ажиллах чадвар нь итгэл хүлээхүйц байхын зэрэгцээ харьяа байгууллагын зорилт, чиг үүрэгтэй давхардаагүй);

Үзэгдэхүйц үйлчилгээний болон стратегийн удирдлагын баримжаатай (агентлагийн бүтэц, бүтцийн нэгжийн нэр нь түүний үйл ажиллагааны стратегийг тусгасан);

Бүтцийн хувьд энгийн байх (агентлагийн даргаас хамгийн доод нэгж хүртэл гурваас дээшгүй шат дамжлагатай байх);

Тэнцвэрийг хангах, хяналтын хүрээг тогтоосон (байгууллагын үйл ажиллагааны стратеги, бүтэц хоёрын зохистой тэнцвэрийг хангах);

Хангалттай чадавх, бодит ажиллагаатай (үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар, зохион байгуулалтын бүтэц нь чадавхаа бүрэн илрүүлж, дайчлахад чиглэсэн, хэрэгжихүйц, ажиллах чадвартай);

Улс төржихгүй (мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлэх, улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүй байх).

3.2. Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар

Агентлагийн бүтцийн ерөнхий тогтолцоо боловсруулахад баримтлах зарчим болон үйл ажиллагааны стратегийн загварыг үндэслэн тус агентлагийн үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загварыг дараах байдлаар үзүүлж байна.

3.3. Зохион байгуулалтын бүтэц

Цаг уур, орчны шинжилгээний газрын үйл ажиллагааны стратегийн болон бүтцийн ерөнхий тогтолцооны загварыг үндэслэн тус агентлагийн зохион байгуулалтын бүтэц, тэдгээрийн үндсэн үүрэг, чиг үүргийг дараах байдлаар тодорхойлсон.

3.3.1. Урьдчилсан мэдээ, цаг агаарын аюулт үзэгдлээс сэрэмжлүүлэх асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

1. Үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд богино болон дунд хугацааны урьдчилсан мэдээ, цаг агаарын аюулт гамшигт үзэгдлээс сэрэмжлүүлэх мэдээллийг олон улсын түвшинд стандарт, арга аргачлалын дагуу боловсруулах, салбарын хэмжээнд нэгтгэн гаргах, орон нутгийн урьдчилан мэдээлэх хэсгүүдийг технологи, арга зүйн удирдлагаар хангах, цаг агаарын урьдчилсан мэдээ, мэдээллийг хэрэглэгчдэд шуурхай хүргэх.

3.3.2. Улсын сүлжээний асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

1. Үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд ус цаг уурын хяналт шинжилгээний улсын сүлжээ, орчны хяналт шинжилгээний тасралтгүй, найдвартай ажиллагааг хариуцах, мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах, хяналт шинжилгээний хөтөлбөр боловсруулах, хэрэгжилт, технологид хяналт тавих, хэмжил зүй, стандартын нэгдмэл байдлыг хангах, сүлжээний техник технологийн шинэчлэл, өргөтгөлийг төлөвлөх.

3.3.3. Технологи инновацын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

1. Үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд ус цаг уур, орчны шинжилгээний салбарын технологи, инновацийн шинэчлэлийг хийх, цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, цаг уурын мэдээллийн технологийн шинэчлэлийн хүрээнд цаг уурын өгөгдөл боловсруулах, загварчлах системүүдийг сайжруулах, өгөгдөл хадгалах, дамжуулах, анализ хийх дэвшилтэт программ хангамж нэвтрүүлэх, үүлэн технологи, их өгөгдөл ашиглан цаг уурын мэдээллийн хүртээмжийг сайжруулах, иргэдэд зориулсан интерактив аппликейшн, платформ хөгжүүлэх;

3.3.4. Архив мэдээллийн сангийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

1. Үйл ажиллагааны стратегийн 5 дугаар зорилтын хүрээнд ус, цаг уур, орчны мэдээллийн төрийн төрөлжсөн архивыг эрхлэх, цахим архив бүрдүүлэх, мэдээ баримтын бүрэн бүтэн, нээлттэй байдал, хадгалалт, хамгаалалтыг удирдан зохион байгуулах, мэдээллийн сангийн удирдлагын системүүдийн сервер, тоног төхөөрөмж, түүний үйлдлийн систем, программ хангамжийн аюулгүй байдлыг хангах, мэдээллийн технологийн шинэчлэл хийх, тоон мэдээ болон цаасан суурьтай мэдээллээр үйлчлэх, өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэх чиг үүрэг хэрэгжүүлэх.

3.3.5. Захиргаа, санхүү, хүний нөөц, хамтын ажиллагааны асуудал

хариуцсан бүтцийн нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

1. Үйл ажиллагааны стратегийн 8 дугаар зорилтын хүрээнд Цаг уур, орчны шинжилгээний салбарыг захиргааны нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, манлайллыг хөгжүүлэх, үйл ажиллагааны менежментийг боловсронгуй болгох, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, салбарын үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэх, хөгжүүлэх;

2. Үйл ажиллагааны стратегийн 7 дугаар зорилтын хүрээнд цаг уур, орчны шинжилгээний салбарын төсвийн төвлөрүүлэн захирагч эрх үүргээ хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, салбарын төсөв, хөрөнгө оруулалт, худалдан авалтыг төлөвлөж хэрэгжүүлэх, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, төсвийг үр ашигтай зарцуулах, тайлагнахад хяналт тавих, санхүүгийн үйл ажиллагаанд зөвлөгөө өгөх;

3. Үйл ажиллагааны стратегийн 6 дугаар зорилтын хүрээнд цаг уур, орчны шинжилгээний салбарын олон улсын байгууллагууд (WMO, UNEP, UNFCCC, RIMES зэрэг)-тай хамтран ажиллах, олон улсын гэрээ, хэлэлцээр, санамж бичиг, хөтөлбөр, төслийг санаачлах, боловсруулж эрх бүхий байгууллагаар батлуулах, гадаад хамтын ажиллагааны богино, дунд, урт хугацааны стратеги, төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтийг хангах, гадаад түнш байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр, сургалт, семинар, уулзалтын зохион байгуулалтыг хариуцах;

3.3.6 Уур амьсгалын өөрчлөлт, орчны шинжилгээний асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

1. Үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд бохирдлын эх үүсвэрийн тооллогыг зохион байгуулах, орчны чанарын болон бохирдлын эх үүсвэрийн мэдээллийн сан бүрдүүлэх, уур амьсгалын өөрчлөлт, түүний үр нөлөөг бууруулахад нөлөөлөх судалгаа хийх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад орчны чанарын төлөв байдлыг мэдээлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, дүгнэлт гаргах, хяналт тавих.

3.3.7. Хяналт, шинжилгээ, дотоод аудитын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

1. Үйл ажиллагааны стратегийн 9 дүгээр зорилтын хүрээнд салбарын бодлого төлөвлөлт, хууль тогтоомж, холбогдох хөтөлбөр, гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа төслийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг үнэлж, дүгнэлт, зөвлөмж гаргах, үнэлгээний талаарх мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг хангах, төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлэх, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт хийх, төрийн албан хаагчийн хууль бус үйлдэл, зөрчилтэй холбоотой өргөдөл гомдол шийдвэрлэх.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын
2025 оны 08 дугаар сарын 29-ны өдрийн
..1692.. дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

Цаг уур, орчны шинжилгээний газрын үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар

